



ТӨВ АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/48

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 заалт, “Орон нутаг дахь мал эмнэлгийн байгууллагын дүрэм”-ийн 3.3.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд Сүмбэр суманд баригдсан Мал эмнэлгийн цогцолбор барилгыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: - П.Батаа (Захиргаа, санхүүгийн албаны дарга)

Гишүүд: - О.Бүрэнжаргал (Мал,)

- Х.Сугарцэцэг (Лабораторийн эрхлэгч)

- Б.Мөнхбаяр (Төв аймгийн Орон нутгийн өмч газрын мэргэжилтэн) зөвшилцсөнөөр

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга - Б.Санчир (Ерөнхий нягтлан бодогч)

2. Төслийн санхүүжилтээр хийгдсэн ажлыг холбогдох хууль, тогтоомж, журам, зааврын дагуу хүлээн авах авч ажиллахыг ажлын хэсэг (П.Батаа)-т даалгасугай.

3. Дээрх барилгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын дагуу байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэж авахыг нягтлан бодогч (Б.Санчир)-д даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн албаны дарга (П.Батаа)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БОЛДБААТАР

